

ОХУ-АСЕАН-Ы ОРНУУДЫН УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*А.Нямдолжин**

1990-ээд оны эхээр ОХУ өрнөдийг хэт ихээр түших, тэдэнд найдах бодлого баримталж байсан бол 1990-ээд оны сүүл үеэс гадаад бодлогодоо зохицуулалт хийж, их гүрний бие даасан бодлогод шилжин, өрнө, дорнын хүчин зүйлүүдийг харгалзсан гадаад бодлого баримтлах болсоны нэг илрэл нь Зүүн өмнөд Азийн улсуудыг хамарсан эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааны нэг чухал байгууллага болох АСЕАН-ы үйл ажиллагаанд идэвхитэй оролцох болсон явдал юм.

1991 оны зун Куала-Лумпурт болсон АСЕАН-ны орнуудын ГЯЯ-ны сайд нарын 24-р чуулга уулзалтанд оросын төлөөлөгчид оролцсон бөгөөд 1996 оноос Орос, АСЕАН-ы орнуудын хоорондын улс төрийн иж бүрэн яриа хэлэлцээний эхлэл тавигдсан. ОХУ, АСЕАН-ы орнуудын хооронд улс төр, эдийн засгийн харилцаа мэдэгдэхүйц идэвхижиж, улс төрийн яриа хэлэлцээ, цаашлаад өндөр албан тушаалтнуудын болон нарийн мэргэжсэн тухайлбал, шинжлэх ухаан, технологи, эрүүл мэнд, худалдаа, хөрөнгө оруулалт, тээвэр дэд бүтцийн зэрэг салбарт Орос-АСЕАН-ы хамтын ажиллагааны хамтарсан хороо, Орос-АСЕАН-ы хамтын ажиллагааны Сан, Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны ажлын бүлэг, Шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны ажлын бүлэг байгуулан ажиллаж байна. ОХУ, АСЕАН-ны орнуудтай хоёр талт хамтын ажиллагаа, улмаар АРФ зэрэг олон талт хамтын ажиллагааны байгууллагаар дамжуулж дээрх байгууллагуудад багтдаггүй бусад улс орнуудыг татан оролцуулах замаар олон талт хамтын ажиллагаанд түлхүү анхаарал хандуулж байна.

Өнөөгийн улам бүр бие биенээсээ хамааралтай болж буй дэлхий ертөнц дээр улс бүр тэгш эрхтэй байж, зөвхөн хамтын ажиллагааны үндсэн дээр бий болсон аюулгүй байдлын олон ургалч дэг жаяг XXI зууны аюулгүй байдлын тулгамдсан асуудлыг шийдвэрлэж бүс нутагт хийгээд дэлхий дахинд энх тайван тогтвортой байдлыг хангах хууль ёсны үндэс болж байна. 9-р сарын 11-ны үйл явдлын дараа олон улсын харилцааны системд гарсан өөрчлөлтийн үр дүнд Ази, Номхон далайн аюулгүй байдлын асуудал чухал ач холбогдолтой болж, олон талын яриа

* А.Нямдолжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хэлцэл өрнүүлэн, үүнийг хэрэгжүүлэх механизм бий болгох үүднээс олон улсын терроризмтэй тэмцэх, үндэстэн дамнасан гэмт хэргийг илрүүлэхэд хамтран ажиллах улс төрийн хамтын ажиллагааны тодорхой баримт бичиг болох АНД-н аюулгүй байдал, энхийг сахиулах түншлэлийн тухай хамтарсан тунхаглалд Орос-АСЕАН-ы гадаад хэргийн сайд нар Пномпень хотноо 2003 оны 6-р сард гарын үсэг зурсан. Энэ нь Орос, АСЕАН-ы орнуудын хамтын ажиллагааны үндсэн чигийг тодорхойлж 2004 оны 7-р сард олон улсын терроризмтэй тэмцэх хоёр дахь хамтарсан тунхаглалаа гаргаж, үүний баталгаа болгон хэдхэн сарын дараа буюу 2004 оны 9-р сард Бандар-Сери Бегаван хотод /Бруней-Даруссалим/ Орос-АСЕАН-ы албаны хүмүүс үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх анхны зөвлөлгөөнийг зохион байгуулсан байна. Ийнхүү АСЕАН-ы гишүүн орнууд орчин үеийн терроризмын аюул заналыг санал нэгтэй хүлээн зөвшөөрч түүний эсрэг хамтран тэмцэх үйл ажиллагаанд нэгдэн орсон юм.

2004 оны 11-р сард Вьентян /Лаос/ хотод болсон АСЕАН-ы 10 дахь чуулга уулзалтын үеэр бүс нутгийн эдийн засгийн үндсэн баримт бичиг болох Зүүн өмнөд Азийн найрамдал, хамтын ажиллагааны гэрээнд /1976 оны Балийн гэрээ/ Орос улс нэгдэн орсоноор Орос-АСЕАН-ы орнуудын яриа хэлэлцээг гүнзгийрүүлэх, бүс нутгийн интеграцид оролцох нөхцлийг бүрдүүлж өгсөн.

2005 оны 12-р сард “ОХУ-АСЕАН”-ы анхны дээд хэмжээний уулзалт Куала-Лумпурт болж, энэ уулзалтын үеэр Орос, АСЕАН-ы орнуудын тэргүүн нар “Орос, АСЕАН-ы хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талыг хамарсан хамтарсан тунхаглал”, түүнчлэн “Орос, АСЕАН-ы хоорондын хамтын ажиллагааг 2005-2015 онд хөгжүүлэх бүрэн хэмжээний хөтөлбөр”-т тус тус гарын үсэг зурсан байна. ОХУ-ын Холбооны Зөвлөлийн олон улсын хэрэг эрхлэх хорооны удирдагч М.Маргелов “Энэхүү уулзалт нь оросын гадаад бодлогын олон талыг онцлон харуулж, Олон улсын исламын бага хурал, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, АСЕАН зэрэг Азийн олон байгууллагуудын үйл ажиллагаанд оросын оролцоог бэхжүүлэх чухал ач холбогдолтой боллоо” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Орос, АСЕАН-ы орнуудын ГЯЯ-ны сайд нарын ээлжит зөвлөгөөн 2007 оны 8-р сард Манилд болж, яриа хэлэлцээний түншлэлийн үндсэн баримт бичгийг хэрэгжүүлэх асуудлыг авч хэлэлцсэн байна. Тухайлбал, худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, соёл, шинжлэх ухаан, технологи, аялал

жуулчлал, эрчим хүч, олон улсын терроризмтэй тэмцэх зэрэг тэргүүлэх салбарууд дахь хамтын ажиллагааг идэвхижүүлэх арга хэмжээ болох “замын зургийг” боловсруулахаар тохиролцжээ.

ОХУ, АСЕАН-ны орнуудын хоорондын худалдааны хэмжээ 2002 онд 2.4 тэрбум ам.доллар, түүний дотор оросын экспорт 1.5 тэрбум ам.доллар, импорт 0.9 тэрбум ам.доллар байв. Энэ нь өмнөх онтой харьцуулахад бараа эргэлт 33%, оросын экспорт 29%, импорт 44%-иар өссөн байна. 1997-2002 онд Оросын АСЕАН-ы орнуудтай хийсэн худалдааны ерөнхий хэмжээ 43%-иар өссөн байна. 2004 онд бараа эргэлт 4.4 тэрбум ам.доллар, 2006 онд 6 тэрбум ам.доллар байв. ОХУ-ын АСЕАН-ы орнуудтай хийж буй худалдааны 70 орчим хувь нь АСЕАН-ы үйлдвэрлэл, технологи, бараа, үйлчилгээ өндөр хөгжсөн Сингапур, Малайз, Индонези, Таиланд зэрэг орнуудад ноогдож байна. Орос АСЕАН-ы орнуудын хоорондын хоёр талын худалдаанд тэнцвэргүй байдал ажиглагдаж байгаа нь Орос, АСЕАН-ны орнуудын удирдагчдын гаргасан эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх олон тооны баримт бичгүүд бодит байдал болон хэрэгжихгүй байгааг гэрчилж байна.

АСЕАН-ы орнуудад гаргаж буй Оросын экспорт нэр төрлийн хувьд хомс байгаа бөгөөд төмөрлөгийн бүтээгдэхүүн, химийн бордоо, цаас, целлюлоз эзэлж, машин, тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн хувийн жин тун бага байна. Орос улс нь АСЕАН-ы орнуудаас гол төлөв байгалийн гаралтай каучук, латекс, далдуу, наргил модны тос, цай, өргөн хэрэглээний бараа, ахуйн цахилгаан бараа импортлодог.

Үүний зэрэгцээ оросын бүтээгдэхүүн нь АСЕАН-ы уламжлалт харилцаатай орнууд болох Япон, Америк, Европ, Хятад, Тайванийн бүтээгдэхүүний бүс нутгийн зах зээл дээрх хурц өрсөлдөөн, оросын зээлийн бодлого явуулах боломж хомс, машин, тоног төхөөрөмжийн чанарын түвшин, экспортын нөөцийн хязгаарлагдмал байдал зэрэг хүчин зүйлээс ихээхэн хамаарч байна.

ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг шинэчлэх, тээвэр, холбооны системийг өргөжүүлэх, барилга, эрчим хүч болон бусад салбарт томоохон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, экспортын барааны төрлийг олшруулах, нэмүү өртөг бүтээх оюуны багтаамж ихтэй бүтээгдэхүүний төрөл рүү хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, гадаад зах зээлийнхээ цар хэмжээг тэлэх үүднээс АСЕАН-ы орнуудад явагдаж буй эдийн засгийн өөрчлөлт нь машин, тоног төхөөрөмж, технологийн эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж байгаа нь оросын экспортын бүтцийн чанарыг

дээшлүүлэх тодорхой бололцоог нээж өгч байна. Оросын экспортын өсөлтийг нэмэгдүүлэх, түүний бүтцийг сайжруулах гол нөхцөл бол техник, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэх, оюуны багтаамжтай бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх явдал юм.

ОХУ АСЕАН-ы орнуудтай улс төр, худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн салбарт хоёр талт хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа нь засгийн газрын болоод парламентын өндөр дээд албаны төлөөлөгчдийн харилцан айлчлал харуулж байна.

ОХУ, Вьетнамын дээд хэмжээний харилцан айлчлал уулзалт тогтмолжин харилцааны эрх зүйн үндэс шинэчлэгдэн бэхжсэн нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн, тогтвортой хөгжүүлэх чухал нөхцлийг хангаж байна. 1994 онд Вьетнамын Ерөнхий сайд Орост, 2000 онд Оросын Гадаад хэргийн сайд И.С.Иванов Ханойд, 2001 онд Вьетнамын Гадаад хэргийн сайд Нгуен Зи Ниен Орост тус тус айлчилжээ. Оросын ерөнхийлөгч В.Путины 2001 онд Ханойд хийсэн албан ёсны айлчлалын үеэр стратегийн түншлэлийн тухай тунхаглалд гарын үсэг зурсан явдал нь хоёр улсын харилцааг цоо шинэ утга агуулга бүхий шинэ үед аваачсан юм. Төдийлөн хангалттай бус байсан хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд ч мэдэгдэхүйц ахиц гарахад нөлөөлсөн. 2000 онд худалдааны хэмжээ 420 сая ам.доллар байсан бол 2003 онд 651.3 сая ам.доллар болж өсчээ. Вьетнам дахь оросын эдийн засгийн гол хөшүүрэг бол хамтарсан газрын хийн “Вьетсовпетро” хэмээх хамтарсан үйлдвэр юм. Энэ хамтарсан үйлдвэрээс Орос улс жил бүр 0.5 тэрбум долларын ашгийг улсын төсөвт оруулдаг байна. “Вьетсовпетро” хамтарсан үйлдвэрийн түүхий хийн олборлолтын хэмжээ 2001-2006 онуудад жилд 11-15 сая тоннын хооронд хэлбэлзэж байв. Орос улс нь вьетнамын эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалтын хэмжээгээр дэлхийн бусад орнуудын дотор 8-р байранд ордог бөгөөд 2006 он гэхэд вьетнамын эдийн засагт 1.7 тэрбум долларын хөрөнгө оруулжээ.

Орос, Индонезийн харилцаа эртний уламжлалтай бөгөөд 1992 оноос хоёр орны тэргүүн нар хоёр талын болон олон улсын харилцааны өргөн асуудлаар харилцан илгээлт солилцож байгаагийн дээр 1997 онд Индонезийн засгийн газрын төлөөлөгчид, түүний дотор зохицуулагч сайд Г.Картасасамита Орост, 1999 оны 3-р сард ОХУ-ын худалдааны төлөөлөгч

Индонезид, түүнчлэн 1996-1997 онуудад Индонезийн Зөвлөлдөх дээд зөвлөл болон Индонезийн батлан хамгаалах, аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн төлөөлөгчид тус тус ОХУ-д айлчилжээ. Оросын ерөнхийлөгч В.Путин, Индонезийн ерөнхийлөгч А.Вахид нарын анхны уулзалт 2000 оны 9-р сард Нью-Йоркт болсон “Мянганы уулзалт”-ын үеэр, хоёр дахь уулзалт нь 2001 оны 10-р сард Шанхайд болсон Ази, Номхон Далайн хамтын ажиллагааны форумын үеэр болжээ. 2003 оны 4-р сард Индонезийн Ерөнхийлөгч М.Сукарнопутри Москвад албан ёсны айлчлал хийж, XXI зууны сайн хөршийн, түншлэлийн харилцааны үндсийн тухай хамтарсан тунхаглалд гарын үсэг зурсан байна. 2005 оны 11-р сарын 19-нд Оросын Ерөнхийлөгч В.Путин Индонезийн шинэ Ерөнхийлөгч С.Б.Юдойонотой Өмнөд Солонгосын Пусан хотноо болсон АТЭС-ийн чуулга уулзалтын үеэр уулзан ярилцаж, олон улсын терроризмтай хамтран тэмцэх асуудлаар болон эдийн засгийн хамтын ажиллагааг зохих төвшинд өргөжүүлэн хөгжүүлэх талаар харилцан санал солилцсон байна. 2006 оны 11-р сарын 29-нд Индонезийн Ерөнхийлөгч С.Б.Юдойоно ОХУ-д, 2007 оны 9-р сарын 6-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Индонезид тус тус албан ёсны айлчлал хийсэн нь хоёр орны харилцааны эрх зүйн гол үндэс суурь болж байна.

2002 оны 9-р сарын 25-нд Москвад болсон Орос-Индонезийн худалдаа, эдийн засгийн хамтарсан комиссын анхдугаар хуралдаан нь хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх гол түлхүүр болж, цаашид энэ талын гэрээ хэлэлцээр байгуулах суурь болсон юм. Загас агнуур болон хөлөг онгоц засварлах салбарт Индонезид хамтарсан үйлдвэр байгуулах үүднээс “Находка” хэмээх эдийн засгийн чөлөөт бүс байгуулах санал тавигдсан байна. Хоёр орны худалдааны хэмжээ 2001 онд 203.5 сая ам.доллар, байсан бол 2004 оноос хоёр орны бараа эргэлт тогтворжин 2007 онд 916 сая ам.доллар болж өсчээ. Орос улс бордоо, химийн бүтээгдэхүүн, хар ба өнгөт төмөрлөг экспортлож, Индонезоос хүнс, хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүн импортлож байна.

Цэрэг, техник, сансарын салбар дахь хамтын ажиллагаа үргэлжлэн хөгжиж байна. 1997 оны 8-р сард Индонезид СУ-30К маркийн 12 онгоц, МИ-17-1В маркийн 8 нисдэг тэрэг нийлүүлэх тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан хэдий ч Азийн санхүүгийн хямралаас болж энэ хэлэлцээрийн хэрэгжилт хойшилсон байна. 2003 онд оросын “Рособоронэкспорт”

компани Индонезид 192 сая ам.долларын өртөг бүхий агаарын техник нийлүүлжээ. 2000 оны 2-р сарын 12-нд оросын пуужин зөөгчөөр индонезийн “Гаруда -1” холбооны хиймэл дагуулыг Байконурын сансрын хөлөг хөөргөх талбайгаас амжилттай хөөргөсөн байна.

Орос, Тайландын харилцаа эрчим хүч болон аялал жуулчлалын салбарт эрчимтэй хөгжиж байна. Тайланд улс нь аялал жуулчлалын салбарт бүс нутагтаа тэргүүн байранд ордог бөгөөд энэ чиглэлээр хамтран ажиллах бүрэн бололцоотой юм. 2005 оны 11-р сарын 18-нд Пусанд (Өмнөд Солонгос) болсон АТЭС-ийн чуулга уулзалтын үеэр оросын “Газпром”, “Внешэкономбанк”, Тайландын “ПТТ Паблик Компани Лимитед”-ийн хооронд стратегийн хамтын ажиллагаа, түншлэлийн тухай хэлэлцээрт гарын үсэг зурсан нь Оросоос Таиланд руу эрчим хүч нийлүүлэх эхлэл тавигдаж цаашид Оростой эрчим хүчний салбар дахь хамтын ажиллагаагаа өргөжүүлэх том хэмжээний төсөл болон өргөжих үндэс болоод байна.

Оросын хувьд Таиландтай хийж буй худалдаа АСЕАН-ы бусад орнуудтай харьцуулахад экспорт-импортын бүтэц, хоёр талын бараа эргэлтийн хэмжээнээс харахад илүү тааламжтай байгаа юм. 2003 онд хоёр орны худалдааны хэмжээ 957 сая ам.доллар байсан нь хамгийн өндөр үзүүлэлт байсан бөгөөд 2003 онд Оросын Ерөнхийлөгч В.Путин Таиландын ерөнхий сайд Т.Чиновит нар худалдааны хэмжээг 1.5 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьснаар 2004 онд 1.3 тэрбум ам.доллар, 2005 онд 1.5 тэрбум ам.долларт хүрч энэ зорилгоо биелүүлж чадсан байна.

Орос, Малайзийн харилцаа, хамтын ажиллагаанд 2003 оны 8-р сард Оросын Ерөнхийлөгч В.Путины Куала-Лумпурт хийсэн албан ёсны айлчлал чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ айлчлалаас хойш хоёр орны харилцаа бүхий л салбарт эрчимтэй хөгжиж байгаагийн дотор цэрэг техникийн салбар дахь хамтын ажиллагаа чухал байр суурийг эзэлж байна. 1994 оноос ОХУ Малайзид 1.7 тэрбум ам.долларын зэрэг зэвсэг нийлүүлсэн байна. 2001-2002 онд Орос, Малайзтай 30 сая ам. долларын өртөг бүхий танк эсэргүүцэх пуужингийн иж бүрдэл “Метис-2”, зөөврийн агаарын иж бүрдэл “Игла” (9К-38) нийлүүлэх гэрээ байгуулжээ. Оросын Ерөнхийлөгч В.Путины 2003 оны айлчлалын үеэр талууд 900 сая ам.долларын өртөг бүхий оросын сөнөөгч “Су-30 МКМ” нийлүүлэхээр тохиролцсон байна.

Хоёр орны худалдааны хэмжээ 2003 онд 740 сая ам.доллар, 2005 онд 987 сая ам.доллар байгаа бөгөөд ОХУ

химийн бүтээгдэхүүн, өнгөт төмөрлөг, машин, тоног төхөөрөмж экспортлож, ахуйн цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмж голчлон импортлож байна. Орос нь Малайзийн Японы дараа хоёрт орох худалдааны түнш болжээ.

Бүс нутгийн томоохон хөрөнгө оруулагч эдийн засаг, санхүүгийн төв болсон Сингапуртай Орос улс харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа бөгөөд 1993 онд ОХУ-ын дэд ерөнхийлөгч, Гадаад хэргийн сайд Сингапурт, 2002 онд Сингапурын гадаад хэргийн сайд Ш.Жаякумар Орост тус тус айлчилжээ.

Орос улс Сингапуртай харилцаа хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхэд Сингапур чухал үүрэг гүйцэтгэж байгаагийн нэг илрэл бол чухамхүү Сингапур 2003 оны 6-р сараас Орос-АСЕАН-ы яриа хэлэлцээний албан ёсны зохицуулагчаар 3 жилийн хугацаатайгаар сонгогдсон явдал юм. 2005 оны “Орос-АСЕАН”-ы анхны дээд хэмжээний уулзалт амжилттай болж өнгөрсөн нь Сингапурын шууд хүчин чармайлтын нэг үр дүн бөгөөд хоёр талын өндөр түвшин дэх харилцан итгэлцлийн илэрхийлэл болсон.

1997, 1998 оны валют-санхүүгийн хямрал хоёр орны худалдаа эдийн засгийн харилцаанд сөргөөр нөлөөлж бараа эргэлт буурахад хүргэсэн хэдий ч 2000 оноос эхлэн худалдаа, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа идэвхижиж 2001 онд хоёр орны бараа эргэлт 421 сая ам.доллар (2000 онд 357 сая ам.доллар), 2002 онд 491 сая ам.доллар, 2005 онд 700 сая ам.доллар болж өссөн байна. Орос улс Сингапурт нефтийн бүтээгдэхүүн (55%), өнгөт металл болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн (31%), хар төмөрлөг (8.3%) экспортлож, ахуйн цахилгаан бараа, компьютер, хүнсний бүтээгдэхүүн, өрөмдлөгийн ажилд зориулсан машин тоног төхөөрөмж, эд анги сэлбэг хэрэгсэл, онгоц болон усан онгоц цэнэглэх түлш импортлодог.

ОХУ-ын хувьд дараах том хэмжээний олон талт төслүүдийн хүрээнд бүс нутгийн интеграцичлалд идэвхитэй оролцох явдал чухал ач холбогдолтой. Үүнд:

1. Меконг голын сав газрыг эзэмших. АСЕАН-ы орнууд дэд бүсийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд олон чухал арга хэмжээ хэрэгжүүлж байгаагийн нэг нь Меконгийн сав газрын эдийн засгийн хөгжлийн асуудал бөгөөд 1996 онд Меконгийн сав газрын хамтын ажиллагааны хороо байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

2. АСЕАН-ы эрчим хүчний сүлжээ, хийн хоолойн системийг барих,

3. “Ази-Европ” хэмээх умраас өмнийг холбосон босоо тэнхлэгийн төмөр замын магистраль барьж байгуулах,

4. “Индонези-Малайз-Тайланд”, “Индонези-Малайз-Сингапур” гэх мэт эдийн засгийн гурвалжин байгуулах. Уг гурвалжингийн гол цөм болсон Сингапурын нөлөө их байгаа бөгөөд Малайз, Индонезид Сингапурын хөрөнгө оруулалт урсан орох болсон учраас энэ гурвалжингийн эдийн засгийн өсөлт үлэмж өсөж байна.

5. 2000 оны 4-р сард Куала-Лумпурт Орос-АСЕАН-ы бизнес форумын үеэр зохиогдсон байгалийн болон техногенийн аюулаас урьдчилан сэргийлэх, дэлхийн мониторингийн иж бүрэн олон улсын системийг байгуулах,

6. АСЕАН-ы гишүүн орнууд Оросын пуужин зөөгчийн тусламжтайгаар хиймэл дагуул хөөргөх зэрэг төсөл болно.

ОХУ нь бүс нутгийн болон олон улсын эдийн засгийн интеграцид гүнзгий нэвтрэх, Ази, Номхон далайн улс төр, аюулгүй байдлын олон талт яриа хэлцэлд идэвхитэй оролцох замаар АСЕАН-ы гишүүн орнуудтай хоёр талт болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиг бодлого баримталж байна.

Оросын хувьд гадаад бодлогын зорилго нь бүс нутгийн олон улсын харилцааны олон туйлт системд бие даасан үүрэгтэй байх, бүс нутгийн хүрээнд АНУ, БНХАУ, Япон зэрэг хүчирхэг гүрнүүдтэй тэнцвэрт, тогтвортой харилцаа хөгжүүлэх явдал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. И.С.Иванов. Новая российская дипломатия. Десять лет внешней политики страны. М.2001. стр. 153.
2. Е.Канаев. АСЕАН и Россия: отношения после холодной войны //Мировая экономика и международные отношения. М. 2007.№2. стр. 73.
3. С.Г.Лузянин. Восточная политика Владимира Путина. Возвращение России на “Большой Восток” (2004-2008 гг.). М. 2008. стр. 320
4. М.Л.Титаренко. Россия лицом к Азии. М. 1998. стр.210
5. www.economy.gov.ru
6. www.mid.ru